

Манай нэрт эрдэмтдийн туурвисан энэхүү бүтээл улс төрчид, бодлого боловсруулагчид болон гадаад харилцааны чиглэлийн практик ажилтан, эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын анхаарал сонирхлыг зүй ёсоор татна гэдэгт найдна.

Г. ТӨМӨРЧУЛУУН.

ПРОЦЕСС ПРИНЯТИЯ ВНЕШНЕ-ПОЛИТИЧЕСКИХ РЕШЕНИЙ В МАЛЫХ ГОСУДАРСТВАХ

(на примере Монголии)

Өнгөрсөн зууны 90-ээд оноос Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын асуудлаар шинэ сэргэг санаа дэвшүүлсэн судалгааны чамбай бүтээлүүд нийтлүүлж олны танил болсон улс төр судлаач, эрдэмтэн, дипломатчидын нэг нь дээрх номын зохиогч Гуудайн Төмөрчулуун юм.

Түүний бичсэн “Жижиг орнуудын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц (Монголын жишээн дээр)” хэмээх нэгэн сэдэвт сонирхол татсан чамбай бүтээлийг Москвагийн “Научная книга” хэвлэлийн газраас 1999 онд 1500 хувь хэвлэн нийтэлжээ. Энэхүү бүтээл өмнөх үг, удиртгал, 6 бүлэг, төгсгөл, хавсралт зэргээс бүрдэнэ.

Зохиогч “Жижиг орнуудын тодорхойлолт, гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц” (онолын үндэслэл) гэсэн тэргүүн бүлэгтээ жижиг орнуудын тодорхойлолт, түүний үндсэн шалгуурт ямар ямар асуудлыг хамруулан авч үзэж буй талаар өрнөдийн эрдэмтдийн онол, гол үзэл баримтлалыг олон улсын харилцааны суурь дэвсгэр дээр системтэй, эрэмбэ дараатай авч үзээд өөрийн үзэл бодлыг илэрхийлжээ.

Дэд бүлэгтээ Монголын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад гадаад орчин тодорхойлогч хүчин зүйл болохыг олон талаас нь нухацтай судалсан байна.

Түүнчлэн их гүрнүүдийн гадаад бодлогод Монгол хэрхэн ямар байдлаар тусч буйг АНУ, ОХУ, БНХАУ-ын жишээн дээр улирлуулан судлаад улмаар Монгол Америк, Монгол Орос, Монгол Хятадын харилцааны уламжлал шинэчлэлийн асуудлыг хөндөж хэтийн төлөвийг нь олон талаас нь харьцуулан судалсан байна.

Эрдэмтэн судлаач Г.Төмөрчулуун Монгол-Оросын харилцааны асуудлыг нэлээд өргөн дэлгэр авч үзжээ. Ингэхдээ гол төлөв XX зууны ерээд оноос хойшхи хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бууралт, өрнөлт, өнөөгийн үйл явцыг нарийвчлан системтэй авч үзсэн байна.

Ялангуяа Оросоос Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын бүтцэд судалгаа хийсэн нь сонирхол татна. Тухайлбал 1990 оноос хойш Монголд Орос Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай 185 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж буй аж.

Оросын талын хөрөнгө оруулалт нийтдээ 23,2 сая ам.доллар байгаа нь гадаадын нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 11,6 хувийг л эзэлдэг байна.

Оросын Монголд оруулсан нийт хөрөнгө оруулалтын 40,8 хувийг хамтын ажиллагааны уламжлалт салбар гэж болох геологи хайгуулын судалгаа, уул уурхайн олборлох салбарт, 21 хувийг инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрт, хөнгөн аж үйлдвэрийн салбарт 16,9 хувийг, эрчим хүчний салбарт 5,6 хувийг, жуулчлалын салбарт 2,6 хувь, бусад салбарт 4,6 хувийг тус тус эзлэж байгаа аж. (54 дэх тал)

Хөрөнгө оруулалтанд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлс, Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн үйлчилгээ, түүний үр нөлөөний асуудлыг ч зохиогч хөндсөн байна.

Г.Төмөрчулуун энэ бүлэгтээ Монгол Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа Зүүн хойт Азийн чиглэлд хэрэгжүүлэхээр зэхэж буй төслүүдэд чиглэвэл илүү үр өгөөжтэй болохыг зөв зүйтэй цохон тэмдэглэжээ.

“Гадаад бодлогын шийдвэр гаргахад гадаад орчны үүрэг роль” гэсэн гутгаар бүлэгтээ зохиогч Монгол улсын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад Орос, Хятадын хоорондын харилцааны хүчин зүйл шийдвэрлэх үүрэгтэй болохыг нээн харуулаад хоёр улсын харилцааны өрнөл, буурал, өнөөгийн үйл явцыг улируулан авч үзсэн байна. Түүнчлэн Оросын хувьд Монгол нь ямар эерэг, сөрөг үр дагавартай байж болох мөн Монголын хувьд Оростой харилцах харилцаанд дээх асуудал ямар үр дагавартай болохыг олон хүчин зүйлээр харьцуулан судалсан нь нэлээд шинэ сэргэг сонирхолтой судалгаа болжээ.

Зохиогч Хятадын хувьд Монголыг хэрхэн авч үздэг, ямар бодлого баримталж ирснийг Хятад Монголын харилцааны асуудлаар судалгаа хийсэн өрнөдийн эрдэмтдийн бүтээлийг Хятадын гадаад бодлоготой харьцуулан судлаад энэ чиглэлээрхи өөрийн байр сууриа илэрхийлжээ.

“Монголын гадаад бодлогод дотоод хүчин үйлс нөлөөлөх нь” гэсэн дөтгөөр бүлэгтээ зохиогч Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд орж шинэ үндсэн хуулиа баталж, олон тулгуурт нээлттэй гадаад бодлого баримталж, үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалаа тунхагласан зэрэг дотооддоо хууль эрх зүйн өөрчлөлт шинэчлэл явуулж ирсэн үйл явцыг хураангуйлан авч үзжээ.

“Гадаад бодлогын шийдвэр гаргахад дотоод орчны нөлөө, үүрэг роль” хэмээх тавдугаар бүлэгтээ зохиогч Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдлыг тухайлбал, ДНБ-ий үйлдвэрлэл, экспорт, импортын бүтэц зэргийг хураангуйлан авч үзсэн байна. Түүнчлэн улс төрийн намууд болон гадаад бодлогын шийдвэр гаргахад нөлөөлдөг бусад хүчин зүйлсийг дэлгэрэнгүй хөндсөн байна.

Дипломатч Г.Төмөрчулуун энэ бүлгийнхээ төгсгөлд Монгол жижиг орны хувьд хүчтэй дипломатын бодлого явуулах шаардлагатай болохыг олон талаас нь нотлоод, түүнд нийцсэн өндөр мэргэжлийн дипломат боловсон хүчин бэлтгэх асуудал маш чухал болохыг хөндөж, өнөөгийн дипломтын ур чадварын шалгуурын асуудлыг дэвшүүлэн тавьжээ. (106 дахь тал)

“Гадаад бодлогын шийдвэр хэрэгжүүлэх үйл явц” гэсэн 6-р бүлэгтээ зохиогч гадаад бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг эрэмбэ дараатай системтэй авч үзжээ. Тухайлбал, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн түүний үүрэг роль, түүнд монголын оролцооны асуудал, түүний ач холбогдол зэргийг тал бүрээс нь нээн харуулжээ.

Эрдэмтэн Г.Төмөрчулууны эл нэгэн сэдэвт бүтээлийн талаар Оросын нэрт монголч, улс төрийн ухааны доктор, Оросын Шинжлэх ухааны Академийн Дорнодахины судлалын хүрээлэн болон Оросын Гадаад Хэргийн яамны Дипломтын Академийн тэргүүлэх ажилтан Г.С.Яскина: “Жижиг орны асуудал, тэр дундаа тэдний гадаад бодлогын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцын талаар дэлхийн улс төр судлалд тун бага судлагдсан. Энэ сэдвээр монголын дипломатч, улстөр судлаач Г.Төмөрчулуун нэгэн сэдэвт бүтээл туурвисан нь улс төрийн шинжлэх ухаанд тэмдэглүүштэй үйл явдал боллоо” гэж өндрөөр үнэлжээ.

Эцэст нь тэмдэглэхэд Монголын нэрийн хуудас болсон цөөхөн эрдэмтэн, дипломатчидын нэг Г.Төмөрчулууны туурвисан энэ бүтээл олон улсын харилцааны мэргэжилтэн, улс төр судлал, олон улсын харилцааны чиглэлийн эрдэмтэн мэргэд, бодлого боловсруулагчид болон их дээд сургуулийн багш, оюутан өргөн олон уншигчдын анхаарал сонирхлыг зүй ёсоор татахуйц онол, практикийн чухал ач холбогдолтой бүтээл болжээ.